



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар

A/68

Улаанбаатар хот

Тоног төхөөрөмж ашиглах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 4.1.3, 4.2.10, 5.4.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны байцаагчийн 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн БД-1400/22 дугаар дүгнэлтийн дагуу Улаанбаатар бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвд Дуун холбооны сэлгэн залгалтын FREQUENTIS VCS3020X, VCX-IP төхөөрөмжийг 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн UTC 00:00 цагаас эхлэн нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээнд ашигласугай.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан техникийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Холбоо, навигаци, ажиглалтын алба (Г.Баттөгс)-нд, Нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйл ажиллагааг Иргэний нисэхийн дүрмийн хүрээнд зохион байгуулж ажиллахыг Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба (Г.Батбулган)-нд, зарлан мэдээлэх ажлыг зохион байгуулахыг Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба (Б.Төгсөө)-нд, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, үйлдвэрлэлийн хэвийн, найдвартай үйл ажиллагааг ханган ажиллахыг Агаарын навигацийн үйлчилгээний газар (Э.Төрбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн газар (Э.Нарантунгалаг)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ

Н.БАТСАЙХАН



1723 01 0468